



МОНГОЛ УЛС
ОЛИМП НИЙТИЙН БИЕЙН ТАМИР,
СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРОО

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 55,
Утас: 261767
И-мэйл: info@ncopas.gov.mn

2024.04.05 № 02/113

танай _____-ны № _____-т

БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
УЛСЫН ХОРООНД

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/22 тоот тушаалын хуулбарыг хүргүүлж байна.

Танилцаад холбогдох хэсгүүдийг хэрэгжүүлж ажиллана уу.

АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА



Э.ТӨМҮҮЖИН

Handwritten signatures and notes, including the date '202400033534' and '2024.04.05'.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Зэсгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.04.02 № 1/1517

танай 2024.01.15 -ны № 01/34 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ОЛИМП,
НИЙТИЙН БИЕЙН ТАМИР,
СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

“Журам батлах тухай” Монгол Улсын сайд,
олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний
хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн А/22 дугаар тушаалыг захиргааны хэм
хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 67.58...
дугаарт бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

151601133
Дос.улам а.5.2024



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 04 сарын 02-ны
өдрийн 6758 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН САЙД
ОЛИМП, НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-ыг нэгдүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хороо /О.Баттулга/-нд үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн "Журам батлах тухай" А/167 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН САЙД, ОЛИМП,
НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 12 сарын 22 өдрийн 422 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙГ БҮРДҮҮЛЭХ СПОРТЫН ТӨРЛИЙГ СОНГОХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, тамирчин, дасгалжуулагчийг сонгон шалгаруулах, тухайн спортын төрлөөр үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах спортын холбоодод тавигдах шаардлага болон улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Үндэсний шигшээ баг нь олон улсын олимпын хороо, олон улсын паралимпын хорооны ивээл дор зохион байгуулагддаг олимпын эрх олгох, оноо цуглуулах, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадамд Монгол Улсыг төлөөлж оролцоно.

1.3.Монгол Улсын өсвөр үе, залуучуудын үндэсний шигшээ багийн үйл ажиллагаатай холбоотой харилцаанд энэ журмыг мөн баримтална.

ХОЁР.СПОРТЫН ТӨРЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

2.1.Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох үйл ажиллагааг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэгт” гэх) сонгон шалгаруулна.

2.2.Ажлын хэсгийг удирдах ажилтныг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Монгол улсын Засгийн газрын гишүүний тушаалаар томилно.

2.3.Ажлын хэсэг нь биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв, Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны төлөөллөөс бүрдсэн байна.

2.4.Ажлын хэсэг нь үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгон шалгаруулах болон үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд орох дасгалжуулагч, тамирчдаас авах шалгалтыг зохион байгуулах бөгөөд улсын төсвөөс дэмжлэг үзүүлэх спортын төрөл, үндэсний шигшээ багийн тамирчид дасгалжуулагчдын тоо, тэдгээрт шаардагдах зардлын тооцооны талаар дүгнэлт гаргана.

2.5.Ажлын хэсгийн нийт гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.6.Ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг удиртгал болгож шударга бус өрсөлдөөн, ашиг сонирхлын зөрчил, авлига хээл хахуулиас ангид байх зарчмыг баримтална.

2.7.Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авах үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийн сонгон шалгаруулалтыг хуанлийн 20-оос доошгүй хоногийн өмнө өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахимаар нийтэд зарлана.

2.8.Сонгон шалгаруулалтын зард бүрдүүлэх баримт бичиг, бүртгүүлэх хугацаа, бусад шаардлагатай мэдээллийг тусгана.

2.9.Сонгон шалгаруулалтад оролцох спортын холбоод дараах материалыг бүрдүүлнэ:

2.9.1 нэр дэвшүүлэх тухай үндэслэл бүхий холбооны хүсэлт;

2.9.2.олон улсын спортын холбоогоор хүлээн зөвшөөрөгдсөн албан ёсны батламж;

2.9.3.спортын холбооны дүрэм;

2.9.4.Биеийн тамир, спортын тухай хуулийн 11.3.6-д заасны дагуу холбооны Удирдах зөвлөлөөс баталсан тамирчин, дасгалжуулагч, шүүгчийн ёс зүйн дүрэм;

2.9.5.холбогдох хуульд заасан үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн хувь /сүүлийн 2 жилээр аудит хийгдсэн/;

2.9.6.энэ журмын 3.1.11-3.1.15-д заасан дүрэм, бүртгэл мэдээлэл, дүгнэлт, Удирдах зөвлөлийн шийдвэрээр төлөөлөх эрх бүхий этгээдийн нэрс;

2.9.7.спортын холбооны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, засаглалын бүтэц, ил тод байдлын баталгаа, холбооны нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийн бодлогын баримт;

2.10.Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ажлын 5 хоногт зохион байгуулна.

2.11.Ажлын хэсэг сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг спортын холбоо, тамирчид, олон нийтэд нээлттэй мэдээлэх үүрэгтэй.

ГУРАВ.СПОРТЫН ХОЛБОО БОЛОН ТАМИРЧИН, ДАСГАЛЖУУЛАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1.Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийн сонгон шалгаруулалтад дараах шаардлага хангасан спортын холбоо оролцоно:

- 3.1.1. олон улсын спортын холбоогоор хүлээн зөвшөөрөгдсөн байх;
- 3.1.2. тухайн спортын төрлөөр олимп, паралимпын наадам, тивийн наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд сүүлийн гурван жил медальт болон шагналт байрт шалгарсан байх;
- 3.1.3. тухайн ангиллын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарсан байх;
- 3.1.4. тухайн спортын төрлөөр улсын хэмжээнд зохион байгуулагддаг тэмцээний тоо, хичээллэгчдийн тоо, материаллаг бааз, хүний нөөцийн хүрэлцээ хангамж, өрсөлдөх чадвар зохих түвшинд хүрсэн байх;
- 3.1.5. спортын холбооны төсвийн зарцуулалт шилэн байх;
- 3.1.6. тухайн спортын холбоо нь Ажлын албатай байх;
- 3.1.7. тухайн спортын төрлөөр үйл ажиллагаа явуулдаг спортын холбооны ерөнхийлөгч, ерөнхий нарийн бичгийн дарга, ажлын албаны ажилтан нь үндэсний шигшээ багийн дасгалжуулагчийн ажил хавсран гүйцэтгэдэггүй байх;
- 3.1.8. спортын холбоо бүр тухайн жилийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын 1/4-тэй тэнцэх хэмжээний эрсдэлийн сантай байх;
- 3.1.9. Авлигын эсрэг хуулийн 4.1.5-д заасны дагуу спортын холбооны удирдах албан тушаалтан болон санхүүгийн ажилтан "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23.3-т заасан хувийн ашиг сонирхол, хөрөнгө оруулалтын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргасан байх;
- 3.1.10. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д заасны дагуу спортын холбооны удирдах албан тушаалтнууд болон дасгалжуулагчид хамаарал бүхий этгээд биш байх;
- 3.1.11. улсын бүртгэлийн гэрчилгээ, шинэчилсэн бүртгэлд хамрагдсан байх;
- 3.1.12. харьяалах нийслэлийн дүүргийн татварын албанд бүртгэлтэй байх;
- 3.1.13. арилжааны банканд улсын төсвийн санхүүжилтийг хүлээн авч, зарцуулах данс нээлгэсэн байх, мэргэжлийн нягтлан бодогчтой байх;
- 3.1.14. холбооны дүрмийн дагуу техникийн, ёс зүйн, шүүгч, дасгалжуулагчийн зөвлөлтэй байх /Удирдах зөвлөлөөр баталгаажсан байх/;
- 3.1.15. санхүүгийн үйл ажиллагаа, тайланд жил бүр аудитын үнэлгээ хийлгэдэг байх;
- 3.1.16. татвар, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын албанд өргүй байх;

3.1.17.биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай өмнө нь гэрээ байгуулсан бол хэрэгжилт, санхүүжилттэй холбоотой тайлан, баримтуудыг гаргаж өгсөн байх;

3.1.18.Үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагчдын ур чадвар, дотоодын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилгоор насанд хүрэгчид, залуучууд, өсвөр үеийн насны ангилалд тэмцээн зохион байгуулдаг байх;

3.1.19.орон тооны болон гэрээт эмч, массажисттай байх;

3.1.20.ёс зүйн зөрчил гаргасан тамирчин, дасгалжуулагчид шийтгэл ногдуулсан, түүнийг биелүүлсэн байх;

3.1.21.холбооны дүрэмдээ Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Допингийн эсрэг үндэсний дүрмийг хатуу баримтлах зохицуулалтай байх.

3.2.Үндэсний шигшээ багийн дасгалжуулагч дараах шаардлага хангасан этгээд байна:

3.2.1.биеийн тамир, спортын чиглэлээр их, дээд сургууль төгссөн, бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх;

3.2.2.Биеийн тамир, спортын тухай хуулийн 16.1-д заасан журмын дагуу спортын сургалт-дасгалжуулалтыг эрх авсан байх;

3.2.3.хувийн ёс зүй, манлайлал, мэргэжлийн ур чадвар, өндөр зэрэглэлийн тамирчидтай ажилласан ажлын туршлагатай, мэргэшсэн байх;

3.2.4.тухайн дасгалжуулагчийн бэлтгэсэн тамирчдын гаргасан амжилт өсөлттэй байх;

3.2.5.олон улсын болон үндэсний спортын холбооны дүрэмд заасны дагуу дасгалжуулагчид тавигдсан холбогдох шаардлагыг хангасан байх;

3.2.6.дэлхийн болон үндэсний допингийн эсрэг дүрэм, стандарт, хориотой бодис, аргын талаар мэдлэгтэй байх;

3.2.7.холбогдох олон улсын гэрээ, конвенц, хууль, эрх зүйн зохих мэдлэгтэй байх;

3.2.8.сүүлийн 2 жилд олон улсын болон үндэсний холбооны дүрмийн дагуу ёс зүй, сахилгын шийтгэл хүлээж байгаагүй, харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай байх;

3.2.9.интернэтийн орчинд ажиллах, компьютерын өргөн хэрэглээний программын дундаас дээш шатны мэдлэгтэй байх (шалгалтын дүн);

3.2.10.гадаад хэлний зохих түвшний мэдлэг, ярианы чадвартай байх (шалгалтын дүн);

3.2.11.спортын шинжлэх ухааны онол, арга зүйн мэдлэгтэй, спортын

анагаах ухаан, эрдэм шинжилгээний сорил, судалгааны үр дүнд анализ хийх, сургалт-дасгалжуулалтын төлөвлөлт, төлөвлөгөөнд тусган ашиглах, өрсөлдөгчийн судалгаа хийх өндөр чадвартай байх (шалгалтын дүн).

3.3.Үндэсний шигшээ багийн тамирчин дараах шаардлага хангасан этгээд байна:

3.3.1.спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн эмнэлгийн үзлэг, ажиллах чадвар, сэтгэл зүйн сорилд орж, өндөр зэрэглэлийн тамирчны тогтоосон нормативыг биелүүлсэн байх;

3.3.2.өндөр амжилт гаргах магадлалтай, ур чадвартай, бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл зүй, бэлтгэлжилтийн түвшинд тавигдах шалгуурт нийцэж эсэх талаар Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн сорил болон эрүүл мэндийн дүгнэлт;

3.3.3.сахилга бат, ёс зүйтэй, харилцааны соёлтой, хариуцлага хүлээх чадвартай байх, харьяалагдах холбоотой ёс зүйн гэрээ байгуулсан байх, нийгэм, залуу үед үлгэр дуурайлал болох, нийгмийн хариуцлагын хүрээнд хүмүүнлэгийн үйлсэд оролцох;

3.3.4.тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадамд медальт болон шагналт байранд шалгарсан байх (сүүлийн 3 жилд);

3.3.5.тухайн спортын төрлөөр өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн, улсын хэмжээний спортын наадамд медальт байранд шалгарсан байх (сүүлийн 3 жилд);

3.3.6.Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, олон улсын болон үндэсний спортын холбооны дүрэм, дэлхийн допингийн эсрэг дүрэм, хориотой эм бэлдмэл, арга, эмчилгээний талаар мэдлэг, мэдээлэлтэй байх;

3.3.7 Допинг хэрэглэхгүй байх батламж гаргах (Допингийн эсрэг үндэсний дүрэм биелүүлэх батламж).

ДӨРӨВ.УЛСЫН ТӨСВӨӨС ҮЗҮҮЛЭХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ

4.1.Спортын холбоонд улсын төсвөөс дараах санхүүгийн дэмжлэг үзүүлнэ:

- 4.1.1.бэлтгэл хийх заал, танхим болон түрээсийн төлбөр;
- 4.1.2.бэлтгэлийн хувцас;
- 4.1.3.тэмцээний хувцас;
- 4.1.4.спортын хэрэглэл материал;
- 4.1.5.эм витамин, тариа, боолт хэрэгсэл, нэмэлт бүтээгдэхүүн;
- 4.1.6.эмнэлгийн үзлэг, оношилгоо;
- 4.1.7.сургалт, сорил, судалгаа;
- 4.1.8.даатгал;
- 4.1.9.дотоодын бэлтгэл цугларалт;
- 4.1.10.гадаадын бэлтгэл цугларалт;
- 4.1.11. олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд оролцох зардал;
- 4.1.12. Засгийн газраас тогтоосон цалин, урамшуулал;

4.2.Биеийн тамир, спортын тухай хуулийн 18.4-т заасны дагуу биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалтаар шалгарсан спортын төрлийн спортын холбоотой Ажлын хэсгийн дүгнэлтийг харгалзаж гэрээ байгуулан ажиллана.

4.3.Монгол Улсын нэрийн өмнөөс олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадамд оролцох үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг спортын холбоо хариуцан зохион байгуулна.

4.4.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.1.8-3.1.13-д заасан шаардлагыг харгалзан энэ журмын 4.1.1-4.1.11-д заасан улсын төсвөөс үзүүлэх санхүүгийн зохих дэмжлэгийг тухайн спортын холбоотой харилцан тохиролцсоны дагуу санхүүжилтийн гэрээнд тусгана.

4.5.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Хяналт шалгалтын нэгжээс эрсдэлийн үнэлгээнд суурилсан санхүүгийн болон үйл ажиллагааны шалгалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу сонгогдсон спортын холбоодод жил бүр хийх үүрэгтэй.

4.6.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.1.12-т заасан цалин, урамшууллыг спортын холбооноос ирүүлсэн үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний мэдээллийг баталгаажуулан олгоно.

4.7.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, спортын холбооны хооронд энэ журмын 4.4-т заасны дагуу байгуулах гэрээ нь тухайн төсвийн жилд хэрэгжих бөгөөд гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэсний үндсэн дээр нэг жилээр сунгана.

4.8.Спортын холбоо нь улсын төсвийн санхүүжилтийг зөвхөн гэрээнд заасан үйл ажиллагаанд зарцуулна.

4.9.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвөөс зөвшөөрсний үндсэн дээр үндэсний шигшээ багийн гишүүдийн орон тооноос хамаарч, тухайн багт дэмжлэг үзүүлэх мэдлэг, туршлага, ур чадвартай эмч, физотерапист, сэтгэл зүйчийг улсын төсвөөс олгох санхүүжилтэд багтаан тодорхой хугацаагаар гэрээнд тусгагдсан бэлтгэл цугларалт, гадаад улсад болох тэмцээний үеэр гэрээгээр ажиллуулж болно.

4.10.Спортын холбоо үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнийг гадаадын улс оронд олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадам болон хамтарсан бэлтгэлд явуулахдаа тухай бүр нислэгийн компанийг сонгохдоо зах зээлийн хямд үнийг сонгоно.

4.11.Спортын холбоо нь улсын төсвийн санхүүжилтээс хэмнэгдсэн төсвийг ажлын 5 хоногт биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад эргүүлэн тушаах бөгөөд дахин зарцуулах шийдвэр гарсны үндсэн дээр санхүүжилтийн гэрээнд тусгагдсан арга хэмжээнд зарцуулна.

4.12. Спортын холбоо тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадамд бэлтгэх зорилгоор тодорхой болзол, хугацаатайгаар тухайн жилийн төсөв, санхүүгийн байдалтай уялдуулан үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, шилжилт хөдөлгөөн хийж болно.

4.13. Спортын холбоо нь Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, шилжилт хөдөлгөөн хийсэн талаарх мэдээллийг сар бүрийн 20-ны дотор Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

4.14. Спортын холбоо нь Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, шилжилт хөдөлгөөн хийхдээ тухайн нэр дэвшигчийг энэ журмын 3.2, 3.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангуулсан байх үүрэгтэй.

4.15. Ажлын хэсэг нь спортын холбоотой байгуулсан тухайн жилийн гэрээг дүгнэж, үйл ажиллагааны аудитын тайланг хэлэлцсэний үндсэн дээр энэ журмын дагуу олгох санхүүжилт, багийн орон тоог нэмэгдүүлэх болон бууруулах талаар дүгнэлтийг гаргана.

4.16. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний дагуу олгосон санхүүжилт, түүний гүйцэтгэлийн тайланг тухайн арга хэмжээг дууссанаас хойш ажлын 14 хоногт багтаан санхүүгийн асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

4.17. Гэрээний дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагааны санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулан дараа оны 2 сарын 10-ны дотор ирүүлнэ.

4.18. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас спортын холбоонд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг дараах тохиолдолд бууруулах, эсхүл хэсэгчлэн зогсооно:

4.18.1. тамирчдын амжилт буурсан;

4.18.2. олимпын эрх авч чадаагүй;

4.18.3. улсын төсвийн санхүүжилтийг гэрээний дагуу зарцуулаагүй, гүйцэтгэлийн тайланг энэ журмын 4.14, 4.15 дэх хэсэгт заасан хугацаанд ирүүлээгүй;

4.18.4. биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн биелүүлээгүй;

4.18.5. татварын болон нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын татвар, шимтгэлийн өр үүсгэсэн.

4.19. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын санаачилгаар спортын холбоотой байгуулсан гэрээгээр олгох санхүүжилтийг дараах тохиолдолд шууд зогсооно:

4.19.1. үндэсний шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчид гадаад улс

орон, дотоодын бэлтгэл цугларалт, тэмцээн, наадамд оролцох үедээ Монгол Улсын нэр хүндэд харшлах аливаа үйлдэл, эс үйлдэл гарган шийтгэл авсан;

4.19.2.үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн олон улс, тив, дэлхийн чанартай тэмцээн, наадамд оролцох эрхийг хассан;

4.19.3.олон улсын спортын холбооноос тухайн спортын холбооны олон улсын гишүүнчлэлийн эрхийг хассан;

4.19.4.үндэсний шигшээ багийн тамирчин тэмцээний болон тэмцээний бус үед допинг хэрэглэсэн нь тогтоогдон олон улсын холбооноос эрхийг нь хассан;

4.19.5.тив, дэлхийн хэмжээний тэмцээн, наадамд оролцоходоо тэмцээний үед баримтлах олон улсын дүрмийг зөрчсөн, эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар хасагдсан.

4.20.Энэ журмын 4.16, 4.17-д заасан шийдвэрийг гарсан даруйд Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

4.21.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага холбогдох хууль болон спортын холбоотой байгуулсан гэрээнд заасны дагуу үндэсний шигшээ багийн үйл ажиллагаа, түүнийг дагалдах санхүүгийн зарцуулалт, гүйцэтгэлд тогтмол хяналт тавина.

4.22. Биеийн тамир, спортын улсын хорооны Хяналт шалгалтын нэгжээс эрсдэлийн үнэлгээнд суурилсан санхүүгийн болон үйл ажиллагааны шалгалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу сонгогдсон спортын холбоодод жил бүр хийх үүрэгтэй.

4.23.Үндэсний шигшээ багт ажиллах гэрээт эмч, физиотерапист, сэтгэл зүйчийн эрхлэх үйл ажиллагаанд Биеийн тамир, спортын улсын хорооны харьяа Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв хяналт тавих үүргийг хүлээнэ.

4.24.Олимп, паралимпын наадамд оролцох эрх аваагүй спортын төрлийг Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнээс Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хасаж, гэрээг цуцална.

ТАВ.БУСАД

5.1.Спортын холбоо үндэсний шигшээ багийн тамирчдын дотоодын бэлтгэл, цугларалтыг Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар баталсан спортын цогцолбор, баазад хийх бөгөөд нэн тэргүүнд биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын харьяа спортын бэлтгэлийн төвийг сонгон зохион байгуулна.

5.2.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас сонгон шалгаруулалттай холбоотой аливаа маргааныг холбогдох хууль, журмын дагуу Монголын олон улсын ба үндэсний спортын арбитраар шийдвэрлүүлэх бөгөөд энэ журам зөрчсөн тохиолдолд сонгон шалгаруулалтыг хүчингүй болгоно.

5.3. Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтсан спортын холбоо, тамирчин, дасгалжуулагч бусад этгээд нь хууль, тогтоомжийн хүрээнд олон улсын спортын холбоо болон үндэсний спортын холбооны ёс зүйн журмыг чандлан мөрдөж, аливаа ёс зүйн зөрчлөөс ангид байна.

5.4. Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтсан спортын холбоо, тамирчин, дасгалжуулагч бусад этгээд нь спортын нийгэм үзүүлэх зэрэг нөлөөллийг идэвхжүүлэх зорилтын хүрээнд нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллана.

---o0o---

